



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар

4/27

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Өргөмжит консулын албан тушаалтан, тэдний тэргүүлсэн консулын байгууллагад хамаарах дэглэмийг хэрэгжүүлэх заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалыг Дипломат төлөөлөгчийн газруудад мэдэгдэх, хэргэжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал (Л.Мөнхтүшиг), хэрэгжүүлж ажиллахыг Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Өргөмжит консулын тухай журам батлах тухай” Гадаад харилцааны сайдын 2016 оны А/54 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101210077

Гадаад харилцааны сайдын 2021 оны  
05 дугаар сарын 27 ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт



**ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН АЛБАН ТУШААЛТАН, ТЭДНИЙ ТЭРГҮҮЛСЭН  
КОНСУЛЫН БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ ДЭГЛЭМИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл**

- 1.1. Энэ зааврыг Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц, консулын харилцааны асуудлаар гадаад улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, “Дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Консулын дүрэм”- д заасан гадаад улсад суух Монгол Улсын Өргөмжит консулын албан тушаалтан, Монгол Улсад суух гадаад улсын Өргөмжит консулын албан тушаалтан, тэдний тэргүүлсэн консулын байгууллага (цаашид “Өргөмжит консулын газар” гэх)-д хамаарах дэглэмийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтална.
- 1.2. Энэхүү зааварт тусгагдаагүй асуудлыг зааврын 1.1.-д заасан олон улсын гэрээ, конвенци болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ХИЛИЙН ЧАНАДАД МОНГОЛ УЛСЫН  
ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН ГАЗАР БАЙГУУЛАХ,  
ӨРГӨМЖИТ КОНСУЛ ТОМИЛОХ**

**2 дугаар зүйл**

**Өргөмжит консулын газар байгуулах зарчим**

- 2.1. Хүлээн авагч улсын зөвшөөрснөөр Монгол Улс гадаад улсад Өргөмжит консулын газар байгуулж болох бөгөөд Өргөмжит консулын газар байгуулах хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй улсад нээн ажиллуулах зарчим баримтална.
- 2.2. Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байрладаг улсад Өргөмжит консулын газар байгуулах шаардлагатай тохиолдолд консулын тойргийг давхардуулахгүй.

### 3 дугаар зүйл Өргөмжит консулын газар байгуулах, өргөмжит консул томилох

- 3.1. Монгол Улсын өргөмжит консулд нэр дэвшигчид дараах шаардлагыг тавина:
  - 3.1.1. Хүлээн авагч улсын иргэн, эсхүл хүлээн авагч улсад байнга оршин суугч Монгол Улсын иргэн байж болно.
  - 3.1.2. Гадаад улсын төрийн албан хаагч байж болохгүй;
  - 3.1.3. Хүлээн авагч улсад гэмт хэрэгт холбогдож, ял эдэлж байгаагүй байх,
  - 3.1.4. 75 хүртэлх настай байх
- 3.2. Хилийн чанадад Монгол Улсын өргөмжит консулаар ажиллах хүсэлтэй иргэн хүсэлтээ дараах материалын хамт холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт, Дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй улсад байгаа иргэний хувьд Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Гадаад харилцааны яам” гэх)-ын Консулын газар (цаашид “Консулын газар” гэх)-т ирүүлнэ:
  - 3.2.1.1. намтар;
  - 3.2.1.2. өргөмжит консулаар ажиллах хүсэлт гаргах болсон шалтгаан, үндэслэл, эрмэлзэл;
  - 3.2.1.3. хүлээн авагч улсын улс төр, бизнес, соёлын салбарын нөлөө бүхий хүний дэмжсэн захидал;
  - 3.2.1.4. ял шийтгэлтэй эсэх талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
  - 3.2.1.5. санхүүгийн чадавхийг нотолсон банкны тодорхойлолт;
  - 3.2.1.6. Өргөмжит консулын газар байрлах газарт тогтмол оршин сууж, үйл ажиллагаа явуулдаг болохыг нотлох бичиг баримт.

Тайлбар: Энэ зааварт заасан “холбогдох” Дипломат төлөөлөгчийн газар гэж тухайн өргөмжит консулын газрын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө өгч, шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, хяналт тавих Дипломат төлөөлөгчийн газрыг ойлгоно.
- 3.3. Энэ зааврын 3.2-д заасны дагуу өргөмжит консулаар ажиллах хүсэлтэй иргэний ирүүлсэн материалыг хүлээн авсан Дипломат төлөөлөгчийн газар нэр дэвшигчийн талаарх саналаа Консулын газарт ирүүлнэ.
- 3.4. Дипломат төлөөлөгчийн газар хилийн чанадад Монгол Улсын Өргөмжит консулын газар шинээр байгуулах, өргөмжит консулд нэр дэвшүүлэх саналыг гаргаж болно. Энэ тохиолдолд нэг буюу хэд хэдэн нэр дэвшигчийг тодруулж, саналын хамт энэ зааврын 3.2-3.3-т заасны дагуу холбогдох материалыг Консулын газарт ирүүлнэ.

- 3.5. Консулын газар Өргөмжит консулын газар шинээр байгуулах, консулын тойргийг тогтоох, өргөмжит консул томилох асуудлаар холбогдох Дипломат төлөөлөгчийн газар, Гадаад харилцааны яамны улс төр, худалдаа, эдийн засаг, соёлын харилцааны асуудал хариуцсан газрууд (цаашид “чиглэлийн газрууд” гэх) болон шаардлагатай тохиолдолд холбогдох бусад байгууллагын саналыг авсны үндсэн дээр Гадаад харилцааны сайдын зөвлөлийн хурал (цаашид “Сайдын зөвлөлийн хуралдаан” гэх)-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 3.6. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хилийн чанадад Өргөмжит консулын газар шинээр байгуулж, өргөмжит консулд нэр дэвшигчийг хэлэлцэн дэмжсэн тохиолдолд хүлээн авагч улсад Монгол Улсын Өргөмжит консулын газар байгуулах тухай хүсэлтийг Консулын газар албан ёсоор хүргүүлнэ.
- 3.7. Хүлээн авагч улс энэ зааврын 3.6-д заасны дагуу хүргүүлсэн хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд өргөмжит консулд дэмжигдсэн нэр дэвшигчийг Гадаад харилцааны сайдын тушаалаар өргөмжит консулаар томилж, патент олгоно.
- 3.8. Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй Өргөмжит консулын газрын тэргүүнд нэр дэвшигчийг энэ зааврын 3.5-д заасны дагуу Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн тохиолдолд Гадаад харилцааны сайдын тушаалаар өргөмжит консулаар томилж, патент олгоно.
- 3.9. Хэрэв хүлээн авагч улс өргөмжит консул томилоход урьдчилсан зөвшөөрөл олгодог журамтай бол урьдчилсан зөвшөөрлийг авсны дараа Гадаад харилцааны сайдын тушаал гаргана.
- 3.10. Консулын патентад өргөмжит консулын овог нэр, зэрэглэл, консулын тойрог, байрлах газрыг заана.
- 3.11. Патентыг гурван хувь үйлдэж, нэг хувийг хүлээн авагч улсын Гадаад хэргийн яаманд хүргүүлж, нэг хувийг өргөмжит консулд гардуулж, үлдэх хувийг архивт хадгална.
- 3.12. Өргөмжит консулын томилолтын хугацаа 4 жил байх бөгөөд хүлээн авагч улс экзекватур олгосон буюу олгохоо урьдчилан нотолсон өдрөөс эхлэн томилолтын хугацааг тооцно.

#### **4 дүгээр зүйл** **Өргөмжит консулын чиг үүрэг**

- 4.1. Гадаад улсад суух өргөмжит консулын үйл ажиллагаа нь Монгол Улсаас суугаа орны чиглэлээр баримталж буй бодлогын тэргүүлэх чиглэлд нийцсэн байх бөгөөд тухайн улстай худалдаа, хөрөнгө оруулалтын

салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, Монгол Улсыг сурталчлахад чиглэнэ.

- 4.2. Өргөмжит консул үүрэгт ажилдаа орсон даруйд түүний үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон гэрээг холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнтэй байгуулна.
- 4.3. Өргөмжит консул нь зөвшөөрөгдсөн консулын тойрогт чиг үүргээ хэрэгжүүлнэ. Онцгой тохиолдолд хүлээн авагч улс зөвшөөрснөөр консулын тойргийн гадна чиг үүргээ гүйцэтгэж болно.
- 4.4. Өргөмжит консул албан байрандаа Монгол Улсын төрийн далбаа мандуулж, монгол хэл болон хүлээн авагч улсын хэлээр “Монгол Улсын Өргөмжит консулын газар” гэсэн бичвэртэй хаяг байрлуулна.
- 4.5. Өргөмжит консул нь түүнд олгосон “Монгол Улсын өргөмжит консул” гэж монгол, англи хэлээр бичсэн, дугаар бүхий тамга ашиглана.
- 4.6. Өргөмжит консул чиг үүргээ гүйцэтгэхдээ Монгол Улс болон хүлээн авагч улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний заалтыг баримтална.
- 4.7. Өргөмжит консул чиг үүргээ гүйцэтгэхдээ Монгол Улсын нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, хүлээн авагч улсын хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхлэхгүй.
- 4.8. Өргөмжит консул нь чиг үүргээ гүйцэтгэсний төлөө Монгол Улсаас аливаа цалин хөлс, урамшуулал, үйл ажиллагааны зардал авахгүй.

#### **5 дугаар зүйл**

##### **Өргөмжит консулын газрыг удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих**

- 5.1. Холбогдох Дипломат төлөөлөгчийн газар нь өргөмжит консулын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө өгч, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.
- 5.2. Холбогдох Дипломат төлөөлөгчийн газар нь өргөмжит консулын жилийн ажлын тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан авч, энэ зааврын 4.2-т заасан гэрээний хэрэгжилтийг дүгнэн жилийн ажлын тайландаа тусгана.
- 5.3. Өргөмжит консулын жилийн ажлын тайлан, гэрээний хэрэгжилтийг чиглэлийн газрууд болон Консулын газар тус тус хариуцсан асуудлаараа дүгнэж, холбогдох Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хариу хүргүүлнэ.

#### **6 дугаар зүйл**

##### **Өргөмжит консулыг чөлөөлөх**

- 6.1. Өргөмжит консулын томилолтын хугацаа дууссан буюу томилолтын хугацааг энэ зааврын 7.1-д заасны дагуу сунгуулах тухай хүсэлтээ ирүүлээгүй бол үүрэгт ажлаас нь чөлөөлнө.
- 6.2. Өргөмжит консулыг томилолтын хугацаанаас нь өмнө чөлөөлөх асуудлыг Консулын газар, чиглэлийн газрууд болон холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг үндэслэн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ:
  - 6.2.1.1. хүлээн авагч улс экзекватурыг цуцалсан буюу түүнийг өргөмжит консул гэж тооцохоо больсон тухайгаа мэдэгдсэн;
  - 6.2.1.2. өргөмжит консул нь энэ зааврын 4.2-т заасан гэрээг ноцтой зөрчсөн, эсхүл томилогдсоноосоо хойш хоёр жилийн хугацаанд тодорхой үр дүнтэй ажил хийгээгүй, эсхүл огт үйл ажиллагаа явуулаагүй;
  - 6.2.1.3. өргөмжит консул гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн;
  - 6.2.1.4. өргөмжит консул үүргээ биелүүлж чадахгүй болсон шалтгаанаа дурдсан өргөдлөө гаргасан;
  - 6.2.1.5. өргөмжит консул төрийн албанд шилжсэн;
- 6.3. Энэ зааврын 6.1-д заасны дагуу өргөмжит консулын томилолтын хугацаа нь дуусгавар болсон, мөн 6.2-т заасны дагуу өргөмжит консулыг хугацаанаас нь өмнө чөлөөлөх саналыг дэмжсэн тохиолдолд Гадаад харилцааны сайдын тушаалаар өргөмжит консулыг чөлөөлж, хүлээн авагч улсад ноот бичгээр мэдэгдэнэ.
- 6.4. Өргөмжит консулыг үүрэгт ажлаас нь чөлөөлмөгц холбогдох Дипломат төлөөлөгчийн газар өргөмжит консулын ашиглаж байсан тамга, холбогдох баримт бичиг болон шаардлагатай бусад материалыг шилжүүлэн авч, Консулын газарт ирүүлнэ.

## **7 дугаар зүйл**

### **Өргөмжит консулын томилолтын хугацааг сунгах**

- 7.1. Холбогдох Дипломат төлөөлөгчийн газар нь хариуцан ажиллаж буй өргөмжит консулын томилолтын хугацааг сунгах саналтай бол энэ тухай саналаа түүний томилолтын хугацаа нь дуусахаас 6 сараас доошгүй хугацааны өмнө Консулын газарт ирүүлнэ.
- 7.2. Консулын газар энэ зааврын 7.1-д заасны дагуу ирүүлсэн саналыг чиглэлийн газруудад танилцуулж, санал авсны үндсэн дээр Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

- 7.3. Өргөмжит консулын томилолтын хугацааг сунгах саналыг Консулын газар эсхүл чиглэлийн газрууд гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг авсны дараагаар 7.2-т заасны дагуу шийдвэрлүүлнэ.
- 7.4. Өргөмжит консулын томилолтын хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд түүний томилолтын хугацааг 4 жилээр сунгах тухай Гадаад харилцааны сайдын тушаал гаргаж, патентыг шинэчлэн олгоно.

### **8 дугаар зүйл**

#### **Өргөмжит консулын зэрэглэлийг өөрчлөх**

- 8.1. Монгол Улсын өргөмжит консул нь дараах зэрэглэлтэй байна.
- 8.1.1. өргөмжит ерөнхий консул;  
8.1.2. өргөмжит консул.
- 8.2. Өргөмжит консулаар 8 жилээс доошгүй хугацаанд ажилласан бөгөөд идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан өргөмжит консулын зэрэглэлийг дэвшүүлэх саналыг холбогдох Дипломат төлөөлөгчийн газар, чиглэлийн газрууд мөн Консулын газар гаргаж болно.
- 8.3. Энэ зааврын 8.2-т заасны дагуу гаргасан саналыг Сайдын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 8.4. Сайдын зөвлөлийн хуралдаанаар өргөмжит консулын зэрэглэлийг дэвшүүлэх асуудлыг хэлэлцэн дэмжсэн тохиолдолд Гадаад харилцааны сайдын тушаалыг үндэслэн өргөмжит консулын патентыг шинэчилж олгоно.

### **9 дүгээр зүйл**

#### **Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх**

- 9.1. Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн Гуравдугаар бүлэг, олон улсын зан заншлын хэм хэмжээ, хүлээн авагч улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **10 дугаар зүйл**

#### **Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулын газар байгуулах**

- 10.1. Гадаад улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны түвшин, онцлог, харилцан адил байх зарчим болон консулын байгууллага байгуулах хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсад гадаад улсын Өргөмжит консулын газар байгуулахыг зөвшөөрнө.

- 10.2. Монгол Улсад өргөмжит консулын газар байгуулах хүсэлтээ тухайн улсын Гадаад хэргийн яамнаас Гадаад харилцааны яаманд ноот бичгээр ирүүлэх бөгөөд уг ноот бичигт дараах мэдээллийг тусгасан байна:
  - 10.2.1. Консулын байгууллагын зэрэглэл, консулын тойрог;
  - 10.2.2. Консулын байгууллага байгуулах хэрэгцээ, шаардлага байгаа тухай үндэслэл
  - 10.2.3. Консулын байгууллагыг тэргүүлэн ажиллуулахаар томилох хүсэлтэй өргөмжит консулд нэр дэвшигчийн овог нэр, намтар;
  - 10.2.4. Консулын байгууллагын байрлах газар болон тус байгууллагын архив байрлах газрын хаяг, холбоо барих утас, факс, цахим шуудан;
  - 10.2.5. Консулын байгууллагын чиг үүрэг, консулын ямар төрлийн үйлчилгээ үзүүлэх талаарх мэдээлэл;
  - 10.2.6. Консулын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, удирдан чиглүүлэх Дипломат төлөөлөгчийн газар.
- 10.3. Монгол Улсад Дипломат төлөөлөгчийн газар нь байрладаг гадаад улсын хувьд Монгол Улсын нийслэлд Өргөмжит консулын газар байгуулахыг зөвшөөрөхгүй.
- 10.4. Гадаад улстай харилцан адил байх зарчим, консулын байгууллага байгуулах хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсад Дипломат төлөөлөгчийн газар нь байрладаг гадаад улсын Өргөмжит консулын газрыг Монгол Улсын аль нэг аймгийн төвд байгуулах зөвшөөрөл олгож болох бөгөөд энэ тохиолдолд тухайн улсын консулын тойргийг давхардуулахгүй.
- 10.5. Консулын газар энэ зааврын 10.2-т заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг үндэслэн чиглэлийн газрууд, тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон шаардлагатай бусад байгууллагын саналыг авсны үндсэн дээр гадаад улсын Өргөмжит консулын газар байгуулах, өргөмжит консулд экзекватур олгох асуудлыг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 10.6. Сайдын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрийг үндэслэн томилогч улсын Гадаад хэргийн яаманд ноот бичгээр хариу мэдэгдэнэ.
- 10.7. Гадаад харилцааны яамны дипломат ёслолын асуудал хариуцсан газар Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулд томилолтын хугацаанд нь хэрэглэгдэх энэхүү зааврын хавсралтаар баталсан загварын үнэмлэх олгоно.
- 10.8. Томилогч улс өргөмжит консулын зэрэглэл, консулын тойргийг өөрчлөх хүсэлтээ дипломат шугамаар бичгээр гаргасан тохиолдолд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

**11 дүгээр зүйл**  
**Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулд нэр дэвшигч,**  
**түүнд тавигдах шаардлага**

- 11.1. Гадаад улсын өргөмжит консулын зэрэглэлийг томилогч улс тогтооно.
- 11.2. Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулд нэр дэвшигчид дараах шаардлагыг тавина:
  - 11.2.1. Монгол Улсад байнга оршин суугч томилогч улсын иргэн, эсхүл Монгол Улсын иргэн байна.
  - 11.2.2. Монгол Улсын төрийн албан хаагч байж болохгүй;
  - 11.2.3. Гуравдагч улсын өргөмжит консулын албыг давхар хашихгүй.
  - 11.2.4. Монгол Улсад гэмт хэрэгт холбогдож, ял эдэлж байгаагүй байх.

**12 дугаар зүйл**  
**Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулд**  
**экзекватур олгох, цуцлах**

- 12.1. Томилогч улсаас олгосон патентыг үндэслэн өргөмжит консулд экзекватур олгоно.
- 12.2. Экзекватур олгосон өдрөөс эхлэн өргөмжит консул үүрэгт ажилдаа орсонд тооцно.
- 12.3. Энэ зааврын 10.8-д заасны дагуу өргөмжит консулын зэрэглэл, консулын тойргийг өөрчилсөн бол экзекватурыг шинэчилж олгоно.
- 12.4. Томилогч улсын Гадаад хэргийн яам өргөмжит консулын бүрэн эрхийг дуусгавар болгосноо Гадаад харилцааны яаманд мэдэгдвэл түүний экзекватурыг цуцална.
- 12.5. Дараах тохиолдолд гадаад улсын өргөмжит консулын экзекватурыг цуцлах асуудлыг Сайдын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж, томилогч улсын Гадаад хэргийн яаманд мэдэгдэнэ:
  - 12.5.1. Өргөмжит консулын үйл ажиллагаа нь Монгол Улсын, олон улсын гэрээ, хууль тогтоомж, үндэсний аюулгүй байдал, ёс уламжлалд нийцэхгүй байвал;
  - 12.5.2. Өргөмжит консул нь Монгол Улсын дотоод асуудал, улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах тохиолдолд;
  - 12.5.3. Өргөмжит консул нь Монгол Улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчих, эрүүгийн хариуцлага хүлээх,
  - 12.5.4. Өргөмжит консул Монгол Улсын төрийн албан хаагч болвол;
  - 12.5.5. Өргөмжит консул гуравдагч улсын өргөмжит консулын албыг хаших болвол.

**13 дугаар зүйл**  
**Гадаад улсын өргөмжит консулын үйл ажиллагаа,**  
**эрх ямба, дархан эрх**

- 13.1. Гадаад улсын өргөмжит консул нь зөвшөөрөгдсөн консулын тойрогт Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн 5 дугаар зүйлийн хүрээнд томилогч улсаас зөвшөөрсөн консулын чиг үүргийг гүйцэтгэнэ. Онцгой тохиолдолд Гадаад харилцааны яамны зөвшөөрснөөр консулын тойргийн гадна чиг үүргээ гүйцэтгэж болно.
- 13.2. Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн Гуравдугаар бүлэг, олон улсын заншлын эрх зүй, Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно.
- 13.3. Өргөмжит консул эрх ямба, дархан эрхээ консулын чиг үүргээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Өргөмжит консулын  
зааврын хавсралт

Гадаад улсад суух Монгол Улсын өргөмжит консулын үнэмлэхний загвар

МОНГОЛ УЛС	ГАДААД ХАРИЛГААНЫ ЯАМ ДИПЛОМАТ ЕСЛӨЛБН ГАЗАР DEPARTMENT OF DIPLOMATIC PROTOCOL MINISTRY OF FOREIGN AFFAIRS	MONGOLIA
<b>ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН ҮНЭМЛЭХ</b> IDENTIFICATION CARD OF HONORARY CONSUL		<b>НС</b>
	ОВОГ / SURNAME <b>ЖАМБААНЯНДАГ / JAMBAANYANDAG</b> НЭР / GIVEN NAME <b>ЖАРГАЛСАЙХАН / JARGALSAIKHAN</b> ТОМИЛОГЧ УЛС / SENDING STATE <b>АЛБАНИ УЛС / ALBANIA</b>	ХАРЬДАЛ / NATIONALITY <b>МОНГОЛ УЛС / MONGOLIA</b> ХҮЙС / SEX <b>М</b>  ОЛГОСОН ӨДӨР / DATE OF ISSUE <b>21.10.2021</b> ХУЧИНГЭЙ ХУТАЦАА / DATE OF EXPIRY <b>21.10.2025</b>
MN150010051	АЛБАН ГУШААЛ / TITLE <b>ӨРГӨМЖИТ КОНСУЛ / HONORARY CONSUL</b>	
ЭНЭХҮҮ ҮНЭМЛЭХ НЬ МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ БОЛНО.		

Энэхүү үнэмлэхийг эзэмшигч нь Монгол Улс дахь гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газрын болон Засгийн газар хоорондын Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын үйлчилгээний ажилтан мөн болно.

Энэхүү үнэмлэх эзэмшигчид хүндэтгэлтэй хандаж туслалцаа үзүүлнэ үү.

**НС**

ГАДААД ХАРИЛГААНЫ ЯАМНЫ  
ДИПЛОМАТ ЕСЛӨЛБН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Үнэмлэхийг биедээ байнга авч явах бөгөөд бусад шилжүүлж үл болно. Гээгдүүлсэн үнэмлэхийг олсон тохиолдолд Улаанбаатар, СБД, Энхтайваны орон чөлөө 7А хайгаар Гадаад хэргийн яаманд авч ирэх буюу 262561 тоог утсанд мэдэгдэнэ үү.